

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсрол соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/90/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn Ахлах аудитор : Б.Дагвасүрэн Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn Аудитор П.Ганцолмон Утас:70157405 Цахим хаяг:uliastaivanaudit@ubaudit.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга	
1.	Аудитын санал дүгнэлт 2
2.	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
2.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
2.2	Аудит хийсэн үр дүнгийн тайлан 5
2.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 7
2.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 8
2.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 10
3.	Аудитын тайлан
3.1	Ерөнхий зүйл 12
3.2	Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт 12
3.3	Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 12
3.4	Материаллаг байдал 13
3.5	Санхүүгийн тайлангийн тодруулга 13
3.6	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 14
3.7	Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг 14
3.8	Аудитын гол асуудал 14
3.9	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, бусад хууль тогтоомж 14
3.10	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 15
3.11	Дараагийн аудитаар анхаарах асуудал 15
4.	Аудитын илрүүлэлт 15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Төрийн аудитын санал, дүгнэлт


**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81090 Улаанбаатар, Завхан аймэг
Утас/Факс: 7046-36-12

БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ
ГАЗРЫН ДАРГА Д.БЯМБАЦОГТ-д

2022.09.29 № 1104/Ж
Төрийн аудитын санал дүгнэлт

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6 дугаар зүйлийн 6.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол шинжлэх ухааны газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсрол шинжлэх ухааны газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудитормын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагач байгууллагаас хараат бус, аудитормын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохиистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ өнгөд эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОВС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

012025333

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА



Хүлээн
Огноо 2022.02.24
Хүннэг
Боловсрол
Д.Бат-Ундраа

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,117,828.57	12,882,158.16
33	АВЛАГА	2,717,939.85	26,169.44
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,717,939.85	26,169.44
35	БАРАА МАТЕРИАЛ	10,399,888.72	10,479,088.72
351	Түүхий эд материал	608,400.00	687,600.00
35110	Тусгай зориулалттай материал	608,400.00	687,600.00
354	Хангамжийн материал	9,791,488.72	9,791,488.72
35420	Аж ахуйн материал	9,791,470.00	9,791,470.00
35440	Тулш, шатах тослох материал	18.72	18.72
36	НӨӨЦИЙН БАРАА	-	2,376,900.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	-	2,376,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	68,063,069.94	80,024,339.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	68,063,069.94	80,024,339.00
392	Биет хөрөнгө	64,723,069.94	76,684,339.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	19,074,400.00	19,074,400.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(19,074,400.00)	(19,074,400.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,680,000.00)	(4,480,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	121,970,190.40	144,497,190.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(96,043,597.12)	(102,946,601.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,241,709.00	33,241,709.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,040,232.34)	(28,652,959.28)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,000,000.00	3,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,325,000.00)	(1,575,000.00)
393	Биет бус хөрөнгө	3,340,000.00	3,340,000.00
39301	Програм хангамж	1,150,000.00	1,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,150,000.00)	(1,150,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,340,000.00	3,340,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	81,180,898.51	92,906,497.16
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	81,180,898.51	92,906,497.16
51	Засгийн газрын хувь оролцоо	81,180,898.51	92,906,497.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		240,015,492.00	240,015,492.00
51101	Өмч: - төрийн	240,015,492.00	240,015,492.00
512	Хуримтлагдсан үр дүн	(165,247,419.55)	(153,521,820.90)
51210	Өмнөх үеийн үр дүн	(165,247,419.55)	(165,247,419.55)
51220	Тайлант үеийн үр дүн	-	11,725,598.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,412,826.06	6,412,826.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	81,180,898.51	92,906,497.16

2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (᠒)	2,057,589,740.89	2,898,650,908.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	105,726,610.89	126,775,035.31
120	Нийтлэг татварын бус орлого	105,726,610.89	126,775,035.31
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,726,610.89	126,775,035.31
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	105,726,610.89	126,775,035.31
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,951,863,130.00	2,771,875,873.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,694,568,100.00	2,420,998,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,694,568,100.00	2,420,998,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	257,295,030.00	350,877,573.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	95,255,110.00	-
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлтэй зээл	-	238,829,740.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	120,854,000.00	15,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,944,640.00	62,678,454.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон	26,241,280.00	34,169,379.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,935,778,220.49	2,886,925,309.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,935,778,220.49	2,886,925,309.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	644,605,651.75	792,682,558.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260,660,167.00	260,820,382.56
210101	Үндсэн цалин	189,719,124.00	186,464,441.56
210102	Нэмэгдэл	55,888,614.00	47,704,735.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,350,100.00	16,899,176.00
210104	Урамшуулал	2,702,329.00	9,752,030.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,786,113.15	33,540,739.26
210201	Тэтгэврийн даатгал	22,359,703.33	27,503,665.95
210202	Тэтгэмжийн даатгал	2,606,603.00	1,793,936.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,085,282.00	999,559.85
210204	Ажилгүйдлийн даатгал	521,319.00	259,269.28
210205	Эрүүл мэндийн даатгал	5,213,205.82	2,984,307.98
2103	Байр ашиг лалттай холбоотой тогтмол зардал	21,723,614.19	14,847,456.52
210301	Гэрэл, цахилгаан	154,104.19	35,456.52
210302	Түлш, халаалт	11,656,720.00	6,227,200.00
210304	Байрны түрээс	9,912,790.00	8,584,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	74,431,006.35	116,679,248.88
210401	Бичиг хэрэг	2,491,300.00	385,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,662,190.28	2,822,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	603,872.07	651,660.57
210404	Ном, хэвлэл	8,639,360.00	10,250.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	32,500.00	180,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	59,001,784.00	343,200.00

Боловсрол соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210409	Тулш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	-	112,286,638.31
2105	Нормативт зардал	9,990,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	9,990,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	175,000.00	-
210604	Урсгал засвар	175,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	9,248,000.00	2,663,300.00
210702	Дотоод албан томилолт	9,248,000.00	2,663,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	92,462,122.00	159,424,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	92,462,122.00	159,424,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,129,629.06	204,707,031.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,215,309.00	8,912,197.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	97,036,320.00	185,229,103.49
210903	Үндсэн жерөнгийн элэгдэл, хорогдол	12,878,000.06	10,565,730.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,291,172,568.74	2,094,242,751.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,204,017,090.00	2,065,434,048.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	919,897,700.00	1,190,828,022.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	281,119,390.00	873,831,858.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	774,168.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	87,155,478.74	28,808,703.01
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	87,155,478.74	28,808,703.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	121,811,520.40	11,725,598.65
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	102,517,924.02	-
225001	Үндсэн жөрөнгө худалдсаны гарз	77,791,244.02	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	24,726,680.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(102,517,924.02)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	19,293,596.38	11,725,598.65

2.3 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	-184,541,015.93	61,887,302.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	-184,541,015.93	61,887,302.13
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	19,293,596.38	
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	(165,247,419.55)	81,180,898.51
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	(165,247,419.55)	81,180,898.51
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	(165,247,419.55)	81,180,898.51
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	11,725,598.65	11,725,598.65
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	-153,521,820.90	92,906,497.16

2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,951,863,130.00	2,771,875,873.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,951,863,130.00	2,771,875,873.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,694,568,100.00	2,420,998,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,694,568,100.00	2,420,998,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	257,295,030.00	350,877,573.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	95,255,110.00	
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	238,829,740.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагддаггүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	120,854,000.00	15,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,944,640.00	62,678,454.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,241,280.00	34,169,379.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,949,913,230.00	2,752,875,873.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,949,913,230.00	2,752,875,873.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	660,740,661.26	658,633,121.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	262,826,220.00	257,773,725.41
210101	Үндсэн цалин	182,775,945.00	168,646,195.41
210102	Нэмэгдэл	60,919,997.00	68,569,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,329,100.00	10,806,000.00
210104	Урамшуулал	7,801,178.00	9,752,030.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,338,000.00	33,895,626.00
210201	Тэтгэврийн даатгал	23,460,000.00	23,742,552.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,469,500.00	2,559,185.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,975,600.00	2,047,148.70
210204	Ажилгүйдлийн даатгал	493,900.00	504,430.77
210205	Эрүүл мэндийн даатгал	4,939,000.00	5,042,307.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,787,899.19	14,847,456.52
210301	Гэрэд цахилгаан	154,104.19	35,456.52
210302	Гулш, халаалт	11,656,720.00	6,227,200.00
210304	Байрны гүрээс	8,977,075.00	8,584,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,183,132.07	4,562,610.57
210401	Бичиг хэрэг	444,700.00	378,000.00
210402	Гээвэр, шатахуун	2,668,500.00	2,822,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	603,872.07	651,660.57
210404	Ном, хэвлэл	129,920.00	17,250.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	32,500.00	319,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	303,640.00	373,800.00
2107	Томилолт, зочны зардал	552,000.00	2,663,300.00
210702	Дотоод албан томилолт	552,000.00	2,663,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,160,700.00	159,394,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	72,160,700.00	159,394,400.00

Боловсрол соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	266,892,710.00	185,496,003.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	172,921,990.00	177,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	93,970,720.00	185,318,303.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,289,172,568.74	2,094,242,751.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,202,017,090.00	2,065,434,048.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	919,897,700.00	1,190,828,022.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад гөрөөс үзүүлэх дэмжлэг	281,119,390.00	873,831,858.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	774,168.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	87,155,478.74	28,808,703.01
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	87,155,478.74	28,808,703.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,949,900.00	19,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,949,900.00	19,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,949,900.00	19,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,949,900.00	19,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,949,900.00	19,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,949,900.00)	(19,000,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,421,008,300.00	2,392,199,166.50	28,809,133.50	99%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,421,008,300.00	2,392,199,166.50	28,809,133.50	99%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	329,606,400.00	326,765,118.50	2,841,281.50	99%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,661,600.00	257,773,725.41	887,874.59	100%
210101	Үндсэн цалин	188,907,600.00	168,646,195.41	20,261,404.59	89%
210102	Нэмэгдэл	56,277,500.00	68,569,500.00	(12,292,000.00)	122%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,560,000.00	10,806,000.00	(246,000.00)	102%
210104	Урамшуулал	2,916,500.00	9,752,030.00	(6,835,530.00)	334%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,768,900.00	33,895,626.00	873,274.00	97%
210201	Тэтгэврийн даатгал	24,891,000.00	23,742,552.69	1,148,447.31	95%
210202	Тэтгэмжийн даатгал	2,469,500.00	2,559,185.86	(89,685.86)	104%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,975,600.00	2,047,148.70	(71,548.70)	104%
210204	Ажилгүйдлийн даатгал	493,900.00	504,430.77	(10,530.77)	102%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,938,900.00	5,042,307.98	(103,407.98)	102%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,862,300.00	14,847,456.52	1,014,843.48	94%
210301	Гэрэл, цахилгаан	92,700.00	35,456.52	57,243.48	38%
210302	Түлш, халаалт	7,019,700.00	6,227,200.00	792,500.00	89%
210304	Байрны түрээс	8,749,900.00	8,584,800.00	165,100.00	98%
2104	Хангамж, бараа материалын зардал	4,606,600.00	4,562,610.57	43,989.43	99%
210401	Бичиг хэрэг	378,000.00	378,000.00	-	100%
210402	Тээвэр, шатахуун	2,822,100.00	2,822,100.00	-	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	529,200.00	651,660.57	(122,460.57)	123%
210404	Ном, хэвлэл	177,900.00	17,250.00	160,650.00	10%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутгал	315,200.00	319,800.00	(4,600.00)	101%
210406	Бага үнэтэй, гургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	384,200.00	373,800.00	10,400.00	97%
2107	Томиллолт, зочны зардал	2,669,200.00	2,663,300.00	5,900.00	100%
210702	Дотоод албан томиллолт	2,669,200.00	2,663,300.00	5,900.00	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,747,300.00	1,731,900.00	15,400.00	99%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,747,300.00	1,731,900.00	15,400.00	99%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,290,500.00	11,290,500.00	-	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	177,700.00	177,700.00	-	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,112,800.00	11,112,800.00	-	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,091,401,900.00	2,065,434,048.00	25,967,852.00	99%
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,091,401,900.00	2,065,434,048.00	25,967,852.00	99%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,190,829,200.00	1,190,828,022.00	1,178.00	100%
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилдаг ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	899,772,700.00	873,831,858.00	25,940,842.00	97%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	774,168.00	25,832.00	97%

2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	350,868,003.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	350,868,003.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	350,868,003.49
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	157,662,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	157,662,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	193,205,503.49
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	193,205,503.49
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,569.51
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	9,569.51
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	350,877,573.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	350,877,573.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	238,829,740.00
131103	ЗГ НХЗДНХөрөнгө, түүнтэй адилгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,678,454.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34,169,379.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Боловсрол Соёл урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Боловсрол Соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 21-ны өдрийн 03/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Боловсрол Соёл урлагийн газар нь сумын Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлж,ажиллах нөхцөл бололцоогоор хангахын зэрэгцээ цаг үеэ олсон,мэргэжлийн зөвлөгөө,дэмжлэгээр шуурхай хангах замаар хууль тогтоомж, бусад эрх зүйн хэм хэмжээний акт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг сумын нутаг дэвсгэрт бүрэн дүүрэн хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий ажлын алба юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Боловсрол Соёл урлагийн газар нь дотоод аудитын нэгж байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Өмнө Боловсрол Соёл урлагийн газрын нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны эхний хагас жилийн нийт орлого 2,771,875.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 27,718.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 19,403.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны эхний хагас жилийн нийт орлого 42,898,650.9 мянган төгрөгийн 1 хувиар буюу 28,986.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 20,290.5 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	2,717.9	26.1	-2,691.8
Бараа	10,399.9	12,856.1	2,456.2
Үндсэн хөрөнгө	68,063.0	80,024.3	11,961.3
Нийт хөрөнгө	81,180.8	92,906.5	11,725.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	81,180.8	92,906.5	11,725.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө	81,180.8	92,906.5	11,725.7

Авлага дансны үлдэгдэл 2,691.8 мянган төгрөгөөр буурсан нь ажилчидтай холбогдсон авлагыг бууруулсантай холбоотой байна.

Бараа материалын данс 2,456.2 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын худалдан авалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 11,961.3 мянган төгрөг болж өссөн нь тайлант онд 22,527.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11,725.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 2,421,008.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,420,998.3 мянган төгрөгийн санхүүжилт, ОУ-ын байгууллагаас 238,829.7 мянга, дээд шатны төсөв захирагчаас хувиарилсан санхүүжилт 62,678.4 мянга, үйл ажиллагааны орлого 34,169.3 мянга нийт 2,420,998.3 мянган төгрөгийн орлого санхүүжилт бүрдүүлсэн байна. Урсгал үйл ажиллагаанд 2,392,199.1 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 28,799.2 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 350,877.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 157,662.5 мянган төгрөгийг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 193,205.5 мянган төгрөгийг, нийт 350,868.0 мянган төгрөгийг зарцуулж улсын төсөвт 9,500,000 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 56 мэдээллийг хугацаандаа мэдээлж, хугацаа хоцроосон мэдээлэл 92, оруулах болоогүй 5 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол Улсын “Шилэн дансны тухай хууль”-ын 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.5, 6.1.6, -г бүрэн хэрэгжүүлж ажиллах. Байгууллага хоорондын тооцоог өглөг авлагын тооцоо үүсгэж байх. Монгол Улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 20.2.5-дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 16,826.3 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлэн, 2,375.3 мянган төгрөгийн зөрчлийг аудитын үед залруулж, 14,451.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний журналд шууд зардалд бичсэн түрээс 759.2 мянган төгрөг, Төсөв захирагчийн тушаалгүй зарлага гаргасан 400.0 мянган төгрөгийн, санхүүгийн үр дүнгийн тайланд 1,216.1 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

4.4 Зөвлөмж

- ✓ Илрүүлэлт: Тайлант хугацаанд 381,577.6 мянган төгрөгийн худалдан авалт хийснийг и баримтын цахим бүртгэлтэй тулгахад 14,451.0 мянган төгрөгийн гүйлгээ нь и баримтгүй байгаа нь нотлогдлоо.
- ✓ Өгсөн зөвлөмж: И баримтыг бүрдүүлээгүй зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий,

нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ." Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Гоо	Дүн	Гоо	Дүн	Гоо	Дүн	Гоо	Дүн	Гоо	Дүн
1	Боловсрол соёлын газар	5	16.8	4	2.4	-	-	-	-	1	14.5